МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 25 өдөр Дугаар А/23 Улаанбаатар хот

Цалингийн сүлжээ батлах тухай

Монгол Улсын "Хөдөлмөрийн тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.2, 51 дүгээр зүйлийн 51.1, "Төрийн албаны тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2.4 , Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 78 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт, МУИС-ийн Дүрмийн 4.5.8.4, 7.3, "МУИС-д Профессор багш ажиллуулах журам"-ын 8.1, Удирдах зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн тогтоол, МУИС-ийн захиргааны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-ийн 2016 оны багш, ажилтны цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралтын дагуу баталсугай.

2. Батлагдсан цалингийн сүлжээний дагуу 2 дугаар хавсралтаар Захиргаа, төвлөрсөн сан, 3 дугаар хавсралтаар Шинжлэх ухааны сургууль /Хүмүүнлэгийн ухааны салбар, Нийгмийн ухааны салбар, Байгалийн ухааны салбар/, 4 дүгээр хавсралтаар Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн, 5 дугаар хавсралтаар Бизнесийн сургууль, 6 дугаар хавсралтаар Хууль зүйн сургуулийн, 7 дугаар хавсралтаар Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн, 8 дугаар хавсралтаар Байгаль-Эх лицей ахлах сургуулийн, 9 дүгээр хавсралтаар Биеийн тамирын тэнхмийн, 10 дугаар хавсралтаар Монгол-Японы хүний нөөц, хөгжлийн төвийн, 11 дүгээр хавсралтаар хавсран ажиллаж буй багш, ажилтны, 12 дугаар хавсралтаар аж ахуйн тооцоотой нэгжүүдийн багш, ажилтны албан тушаалын зэрэглэл, түүнд харгалзах цалинг тус тус тогтоосугай.

My document.Tushaal.2016.January
20160203

3. Багш, ажилтнуудын цалин хөлсийг батлагдсан сүлжээний дагуу 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг Шинжлэх ухааны сургууль, Бизнесийн сургууль, Хууль зүйн сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль, Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль, Байгаль-Эх лицей ахлах сургууль, төвлөрсөн сангийн ахлах нягтлан бодогч (Л.Оюун-Эрдэнэ, Ч.Байгалмаа, Ш.Төгсбаяр, Ш.Мөнхцэцэг, М.Батбямба, Г.Оюундэлгэр, Х.Батдорж) нарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн бодлогын асуудал эрхэлсэн дэд захирал (Ч.Нарантуяа), Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний албаны дарга (В.Батцэнгэл), Бүрэлдэхүүн сургуулийн захирал (Б.Баяртогтох, Ц.Болормаа, Ж.Эрдэнэбулган, Н.Баатарбилэг, С.Баттулга) нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ Р.БАТ-ЭРДЭНЭ

УХД0072 9104399

D:Tushaal.2016